БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрх дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн 2 (хоёр) аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг хавсралтад зааснаар дуусгавар болгосугай.

2.Газар эзэмших эрх нь дуусгавар болж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариу мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/111 дүгээр захирамжийг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

122501005З

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 сарын 10 -ны өдрийн 106 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ НЬ ДУУСГАВАР БОЛГОЖ БАЙГАА
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Д/д	Газар эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын		Газрын				
	Нэр	Регистр	Байршил	Зориулалт	Хэмжээ м2	Эдэлбэрийн хэлбэр	Өмнө нь гарсан ДЗД-ын захирамж шийдвэр
1.	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	1653229	1-р хороо, Өндөртолгой	Орон сууц	1585	Эзэмших	2014 оны А/111
2.	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	1653229	1-р хороо, Өндөртолгой	Орон сууц	841	Эзэмших	2014 оны А/111